

АГУУЛГА

1. Төслийн танилцуулга
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн өнөөгийн төлөв
3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төлөвлөгөө
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө
15. Нэгдсэн зардал

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Эрвэй хошууны овоо” төмөр-цайрын ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл.

Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж, байгууллагын нэр: “Каскейд Майнинг” ХХК


- Улсын бүртгэлийн дугаар: 9019058053
- Регистрийн дугаар: 5463599
- Лицезийн дугаар: MV-012328

Төслийн зорилго: Нөөцийг иж бүрэн ашиглах, техник технологийн шийдлийг оновчтой зөв гаргах, нөхөн сэргээлт, ажиллагсдын хөдөлмөр хамгаалал эрүүл мэнд, орон нутаг дэд бүтцийн хөгжилд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах.

Төсөл хэрэгжих хугацаа: 2022-2025 он

Төслийн хүчин чадал Ил уурхай: Ордыг 5 жил ил уурхайн аргаар ашиглаж, ашиглалтын хугацаанд 471.9 мян.тн хөрс хуулж, 345.07 мян.тн хүдэр олборлохоор тооцсон ба 210 хоногийн хугацаанд олборлолтыг бүрэн явуулж дуусгана. Ил уурхай үндсэн 1 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллана. **Баяжуулах үйлдвэр:** Жилд 334 хоног ажиллах ба төмрийн хүдэр 116 719.73 тн, цайрын хүдэр 26 903.1 тн баяжуулна. Баяжуулах үйлдвэр нь 1 ээлжээр, ээлжинд 10 цагаар ажиллана.

Төслийн байршил: Тус орд нь Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос 110 км, Сүхбаатар сумаас зүүн хойш 54 км, Чойбалсан хотоос баруун урагш 120 км, Хэнтийн-Сүмбэр сумыг дайран өнгөрөх мянганы замаас урагш 20 гаруй км, Сүхбаатар-Дорнод аймгуудыг холбосон өндөр хүчдэлийн шугамаас 20 км зайд оршино.



Төсөл хэрэгжих газрын байршил

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ

Ашиглалт явуулах талбай нь газарзүйн байршлаар Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших ба Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос 110 км, Сүхбаатар сумаас зүүн хойш 54 км, Чойбалсан хотоос баруун урагш 100 км, Хэнтийн-Сүмбэр сумыг дайран өнгөрөх мянганы замаас урагш 20 гаруй км, Сүхбаатар-Дорнод аймгуудыг холбосон өндөр хүчдэлийн шугамаас 20 км зайд оршино.

Газрын гадаргуу: Эрвэн хошууны овоо төмөр, цайрын орд нь Монгол-Агнуурын атираат бүсийн зүүн Монголын геосинклиналь өргөгдлийн буюу Говь-Алтай-Сүхбаатарын бүтэц хэлбэршлийн бүсийн хэмжээнд байрлана. Энэхүү төмрийн илрэл нь Төмөртийн овооны цайрын уулын баяжуулах үйлдвэрээс зүүн хойш 80 км, Арын нуурын зэс мольбдений ордоос зүүн тийш 10 км -т оршино. Уг илрэл нь Дорнод Монголын металагени их мужийн Сүхбаатарын холимог төмөрлөгийн хүдрийн дүүрэгт буюу Арын нуур, Мухар эргийн овоо, Эрвэн хошууны овоо гэсэн хүдрийн зангилаанд байрлана. Эрвэн хошууны овоо уурхайн талбай нь тал хээрийн бүс дахь Сүхбаатар оройтой намхан уул, тэгшэвтэр тал бүхий бүсэд хамаарна. Талбайн үнэлэхүй өндөр 850-950м-ийн хооронд хэлбэлзэх ба хамгийн өндөр уул нь талбайн урд хэсэгт орших Цагаан өндөр (1047.0м), хамгийн намхан цэг нь талбайн зүүн хэсэг дэх Холбоогийн говь (840 м) бөгөөд талбайн ихэнх хэсгийг (70%) тал, хөндий эзэлнэ. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 902.5-964.3 метрийн үнэмлэхүй өндөрт байрлах ба газрын гадаргын хэвгий буюу налуу төслийн талбай нь районд 1.42-6.97 (градус)-т байна. Одоогийн байдлаар олборлолтын явцад ил уурхайн гүн нь 40 орчим метрт хүрсэн байгаа ба нийт 32.6 орчим га талбай эвдрэлд өртсөн байна.

Усан сүлжээ: Талбайн хэмжээнд усан сүлжээ дунд зэрэг хөгжсөн бөгөөд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. Түр зуурын борооны уснаас үүссэн тогтмол нуурууд, гар болон өрөмдмөл худгууд талбайн хэмжээнд элбэг тохиолдоно. Эдгээр худгуудын ихэнх нь техникийн болоод ундны хэрэгцээг хангадаг. Худгийн ундарга 150-800 л/ц хүрэх ба Жавхлант овооны худгийн ундарга 1650-1800 л/ц гэж тогтоосон байдаг.

Цаг агаар: Төслийн талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилд унах хур тунадасны хэмжээ 205-220 мм орчим бөгөөд хур тунадасны ихэнх нь 7,8,9-р саруудад ихэвчлэн уулархаг нутгаар унадаг. Дэлхийн дулааралтай холбоотойгоор талбайн хэмжээнд сүүлийн жилүүдэд жилд унах хур тунадасны хэмжээ 30-50 мм-ээр багасаж байгаагийн улмаас орон нутгаар гандуу болж өвс ургамлын гарц эрс муудаж байна. Жилийн дундаж температур +6.4 ОС, хамгийн дулаан улирал нь 7,8-р сард +35ОС, хамгийн хүйтэн үе нь 1-р сард -25ОС хүрдэг. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба салхины хурд дунджаар 1-2м/с байх ба хамгийн их салхи шуургатай улирал нь 5-6 сард болдог. Энэ үед салхины хурд 10 м/с-ээс дээш салхилна. Зарим жилүүдэд тухайлбал 2008 онд байгалийн гамшиг болоход цасан болон шороон шуурга 5-6 хоног үргэлжилсэн ба салхины хурд 25-28м/с хүрсэн тохиолдол тэмдэглэгдсэн.

Хөрс, ургамал ба ан амьтан: Хөрсний хувьд говь, хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хөрс үүсэхэд хур тунадас, салхи ихээхэн үүрэгтэй. Салхи нь хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж ууршилтыг ихэсгэснээр хөрс хуурайшихад нөлөөлөөд зогсохгүй хөрсний өнгөн хэсгийг хийсгэж нүүлгэн хөрс эвдэхэд ихээхэн нөлөөтэй. Хур бороо элбэг үед ургамлын бүрхэвч сайжирч хөрсний эвдрэл үүсэх нөхцөлийг багасгана. Тэгш өндөрлөг газруудад бор саарал, саарал хөрс зонхилж,

мараалаг борзон хайрга, чулуун хуягаар зарим газраа бүрхэгдэнэ. Хонхор хотгор газруудаар хужир тойром, мараалаг хөрс элбэг тархана. Зарим газруудын ар хормой бэлээр элсэрхэг хөрс зонхилно. Ургамал зүйн хувьд тал хээрийн ургамал зонхилон ургана. Талбайн хэмжээнд ургамлын бүрхэвч сайн хөгжсөн бөгөөд говирхог нутгаараа баглуур, дэрс, бударгана зэрэг бутархаг ургамал, талархаг газраараа хиаг, таана, агь, хөмүүл ургана. Ан амьтан. Судалгааны талбайн орчимд чоно, үнэг, хярс, өмхий хүрэн зэрэг араатан, цагаан зээр, хар сүүлт зэрэг сүүн тэжээлтэн, хулгана, зурам, тарвага зэрэг мэрэгч амьтад амьдардаг. Нугас, галуу, хун г.м нүүдлийн шувуудаас гадна бүргэд, тас, шонхор, тагтаа, болжмор, хараацай зэрэг шувууд амьдардаг.

Цахилгаан хангамж: Эрвэн хошууны овоо төмрийн хүрийн ордыг ашиглах уурхайн ашиглалтын жилүүдэд цахилгаан эрчим хүчний үүсгүүр нь Чойбалсан-Баруун-Уртын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дизель станцын үр ашигтай хувилбар байх юм.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Энэ нутагт Халх Монголчууд нутагшин амьдрах ба үндсэн эрхлэх аж ахуй нь мал аж ахуй болдог. Сүхбаатар сумын төвд сумын захиргаа, хүн эмнэлэг, холбоо, дунд сургууль, шатахуун түгээх станц, дэлгүүр, хилийн цэргийн отряд, Мобикомын станц, дизель станц, соёлын төв зэрэг соёл үйлчилгээний байгууллагууд ажилладаг. Одоогийн байдлаар судалгааны талбайн баруун хойно орших Тал булгийн нүүрсний уурхайд олборлолтын ажил явагдаж байна. Хүн амын ихэнх нь халх үндэстэн бөгөөд тэдгээр нь гол төлөв мал аж ахуй эрхлэхээс гадна сумын төвд төрд алба хаах эсвэл, хувийн хэвшлийн болон улсын үйлчилгээний газарт ажиллаж амьдардаг. Сүхбаатар сум нь аймгийн төв болон бусад сумуудтай утсан харилцаагаар болон түүнээс гадна Мобикомын сүлжээнд хамрагдсан тул холбоо харилцааны хувьд найдвартай. Сумын төв болон хөдөөгийн малчид сансрын антены тусламжтайгаар телевизийн үйлчилгээг авдаг бөгөөд тэдгээртэй шороон замаар холбогдоно.

Дэд бүтэц: Судалгааны талбай нь дэд бүтэц сайн хөгжсөн дүүрэгт байрлах ба уг талбай нь Улаанбаатар хотоос 650 км, Баруун-Урт хотоос 110 км, Сүхбаатар сумаас зүүн хойш 54 км-т байрлах ба хоорондоо шороон замаар холбогдоно. Мөн Тал булгийн нүүрсний уурхайгаас 75 км, Чойбалсан-Баруун-Уртын өндөр хүчдэлийн шугамаас 20 км, Чойбалсан хотын Баянтүмэнгийн төмөр замын өртөөнөөс 120 км зайд байрлаж байгаа нь дэд бүтцийн таатай орчинг бүрдүүлж байгаагийн дээр судалгааны талбайгаас хойш 30 орчим км зайтай Мянганы зам тавигдахаар төлөвлөгдөж байгаа нь тус ордын хувьд зам харилцаа, дэд бүтцийг хөгжүүлэх бүрэн боломжтойг харуулж байна. Дээрх сум, уурхайн төвүүд нь төвийн эрчим хүчний өндөр хүчдэлийн шугаманд холбогдсон байдаг.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль экосистемийн өөрчлөлт: Эрвэн хошууны төмрийн хүдрийн ил уурхайн хүрээнд нийт 63.4 мян.тн хүдэр олборлож, 127.8 мян.т хөрс хуулна. Хөрс хуулах, олборлолтын ажлын технологийн үндсэн процесс нь өрөмдлөг-тэсэлгээ, ухаж ачих, тээвэрлэх /дотоод болон гадаад/ гэсэн дэд процессуудаас бүрдэнэ. Иймд геологийн тогтцыг эвдэж өөрчлөх, газрын нөөц баялгийг ашиглах явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна. Тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох геологийн тогтоц, хөрс, бэлчээрийн ургамалд шууд нөлөөлж буй бөгөөд эдгээр нь урт хугацааны хүчтэй нөлөөлөлд хамрагдах бөгөөд ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн зэрлэг ан амьтад үргэн дайжих, тоос шороо дэгдэн бичил уур амьсгалын нөхцөл богино хугацаагаар бага зэрэг өөрчлөгдөж болох юм.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд Монгол улсын Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын хууль, Байгаль хамгаалах хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, байгалийн баялгийг алдагдал хаягдалгүй бүрэн ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж байх үүрэг ут уурхайд ногдож байгаа юм. Байгаль орчны чанарын өөрчлөлт: Төслийн үйл ажиллагааны үр дүнд уурхайн ашиглалтын давхаргад шатах тослох материал, тэсрэх бодисын хэрэглээтэй холбоотойгоор газрын доорх усны чанарт өөрчлөлт орох магадлалтай юм. Энэ нөлөөлөл нь урт хугацаанд /газрын доорх усанд нэвчсэн шатах тослох материалын задрал нарны энерги байхгүй учир удаан байна /буцалттай / хэдийн задрал удаан боловч тодорхой хугацааны дараа ус цэвэрших боломжтой /удаан хугацаанд шатах тослох материалаар бохирдсон уснаас мал, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дагавар нь дунд зэрэг учир эрчим нь дунд зэрэг байна. Тэсрэх бодисын ашиглалттай холбоотой хүний эрүүл мэндэд /тэсрэх бодистой харьцаж байгаа ажилчид/ сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай /эрсдэлийн үнэлгээний хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү/.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор: Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд энэ нөлөөлөл нь тусгай зөвшөөрлийн талбайтай харьцуулбал бага хэдийн ч байгалийн бус уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас 5.0 га талбай ил уурхайн ухаш, 21.66 га талбай хөрсний овоолго, 2.9 га талбай технологийн зам, 3.04 га хүдрийн агуулах, бусад дэд бүтцийн объект зэрэг үүссэнээр тухайн нутгийн ландшафтын хүчтэй өөрчлөлтөд орсон байна. Нийгэм, эдийн засаг: Уг төсөл хэрэгжсэнээр ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах, нийт 157 хүнийг ажлын байраар хангана, тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Ашиглалтын хугацаанд цалинд 1705.0 сая, жилд дунджаар 569.0 сая төгрөг тусгагдсан байна. Уурхайн ажилдчын сарын дундаж цалин 1.32 сая төгрөг байна. Ашиглалтын хугацаанд 3205.2 сая.төг улс орон нутгийн төсөвт оруулахаар байна. Эдгээр нь шууд бөгөөд богино хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл: Тус төмөр цайрын хүдрийн уурхай нь хуурай хээрийн экосистем бүхий нутагт байрлах тул төмрийн хүдэр олборлох технологийн бүхий л үе шатанд тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхээс болгоомжлох шаардлагатай болно. Ил уурхайн аргаар байгалийн эрдэс баялгийг олборлодог уурхайн хувьд онц аюултай хүчтэй салхи, уруйн үер (хүчтэй аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал: Эрвэн хошууны төмөр цайрын хүдрийн орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг Монгол улсын Ашигт Малтмалын Газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар баталгаажуулсан нь технологийн хувьд хамгийн оновчтой хувилбар гэж үзсэний баталгаа болох юм. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заагдсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор энэ чиглэлийн мэргэжилтэн авч ажиллуулан, улирал тутам ил уурхайд ажиллах ажилчдын дунд сургалт явуулж шалгалт авч байхаар ТЭЗҮ-д тусгасан байна. Мөн БОННУ-ний тайлангийн эрсдэлийн үнэлгээний хэсэгт тодорхойлсон аюул ослын үнэлгээний үр дүн, Монгол улсын хууль эрхзүйн баримт бичгийн заалт бүрийг хангаж ажиллах хэрэгтэй.

Нөлөөллийг тодорхойлох шалгуур	Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд
Төслийн байршилтай холбоотой шалгуурууд	
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	Төслийн талбайгаас баруун хойш 19.3 км-т Баянцагааны тал БНГ, урд зүгт 47.3 км-т Дархан хаан уулын ДГ зэрэг УТХГ нутгууд байрласан байна. Мөн ОНТХ Жаран тогоон төслийн талбайгаас зүүн зүгт 19 км-т, Мөгдөгөөс холбоот толгой төслийн талбайгаас баруун зүгт 9 км-т, Шаврын 3-н толгой төслийн талбайгаас баруун урд зүгт 16 км-т, Эрдэнэ овоо төслийн талбайгаас баруун урагш 45 км-т тус тус Сүхбаатар сумын тусгай хамгаалалтай газар нутгууд байрласан байна
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх	Орон нутагт салхины нөлөө ихтэй Жилд орох хур тунадас бага хуурайшилт их Хээрийн түймрийн аюул их
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Уг уурхай Сүхбаатар аймгийн төвөөс Дорнод аймгийн Чойбалсан хотын чиглэлийн зам дагуу байрлана. Ойрын хугацаанд төлөвлөсөн төлөвлөлт байхгүй.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Төсөл хэрэгжих хугацаа дунд, хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээлтийн чиглэлийг ашиглана уурхайг хаасны дараа нөхөн сэргээх бүрэн боломжтой.
Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд	
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх	Уурхайн тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт; Уурхай ашиглалтын үед үүсэх тоос Тэсэлгээний үеийн тоос Хүдэр бутлах, ачих үед үүсэх тоос Техник тоног төхөөрөмжийн дуу чимээ Ахуйн хог хаягдал, бохирын үнэр.
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл: Усны нөөцөд хомсдол үүсэх, эсэх Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх Ус бохирдуулах, эсэх	Уурхайн ашиглалтын бүсэд гадаргын ус байхгүй уурхайн ус шүүрүүлэлтийн улмаас гүний усны хомсдол үүснэ. Баяжуулах үйлдвэр болон унд ахуйн хэрэгцээний усыг төслийн талбайд байрлах 3.0 л/с ундарга гүний худгийн уснаас, тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлтэнд шаардлагатай усыг уурхайн шүүрлийн усаар (шүүрлийн усны ундарга 1.63 л/с) хангана. Технологийн хэрэглээнд жилд 58 340.3 м3 ус ашиглана. Унд, ахуйн хэрэглээнд жилд 3366.72 м3 ус ашиглана
Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд	
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө: Хөрс эвдрэх эсэх Хөрс бохирдох эсэх Хөрс доройтох цөлжих эсэх	Төслийн үйл ажиллагаагаар хөрсийг хуулж эвдэх, талхалж доройтуулах; Техник ашиглалт, засвар үйлчилгээ, шатах тослох материалын хэрэглээ, ахуйн хог хаягдал зэргээс хөрсний бохирдол үүсэж болзошгүй;
Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө: Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх	Хөрс хуулснаар ургамлан нөмрөг биет хэмжээгээр устаж, тодорхой хэмжээний газар талбайд нөмрөг ургамалгүй болох; Газар хөрс талхлагдсан газруудад ургамлан нөмрөг талхлагдан халцрах; Бүтээн байгуулалт, тээвэрлэлтийн тоосны нөлөөгөөр ургамлын ургах орчин доройтох;
Ан, амьтанд үзүүлэх нөлөө: Зэрлэг амьтдын амьдрах	Бэлчээрээр идээшилдэг том хөхтөн амьтад дүрвэж зугтах тул бэлчээрээр шахагдах; Төсөл хэрэгжих бүс нутагт ховор амьтны

орчныг доройтуулах эсэх Ховор болон нэн ховор амьтан өртөх эсэх	тархацгүй тул сөрөг нөлөө илрэхгүй. Шувуудад тодорхой сөрөг нөлөө үзүүлэх байдал үгүй.
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд:	
Орон нутгийн оршин суугчдад үзүүлэх нөлөө: Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх эсэх Оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөтэй эсэх Нөлөөлөлд өртөж болзошгүй төв суурин газар байгаа эсэх Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх	Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд айл, малын суурьшил үгүй тул газар ашиглалтад сөрөг нөлөө үзүүлэхгүй. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын төв төслийн талбайгаас зүүн хойш 54 км зайд байрлана. Төслийн нөлөөллийн бүсэд суурьшил байхгүй тул нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэхгүй.
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд:	
Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөө: Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйл бий эсэх	Төслийн талбай хамгийн ойр орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг баруун зүгт 9 км зайд байна. Уурхайн нөлөөллийн бүсэд түүх соёлын үнэт зүйл байхгүй болно
Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Нутгийн иргэд, оршин суугчдад сөргөөр нөлөөлөх эсэх Төслийн бүхий л үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх эсэх	Уурхайн тэсэлгээний ажлын үед хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл Үйлдвэр технологийн үйл ажиллагаанд химийн хортой болон аюултай бодис тэсрэх бодисын зөв зохистой хэрэглээгүйгээс Төслийн хэрэгжилтийн хүрээнд дагаж мөрдөх хөдөлмөр хамгааллын харилцааг төслийн ТЭЗҮ-д тусгайлан заасан бий.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний /БОННУ/ үр дүнд үндэслэн 2019 оны 10 сарын 29-ны өдөр А-618 тоот Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайд /БОАЖЯС/ А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам болон бусад холбогдох дүрэм журам, стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн болно.

Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу төрийн захиргааны байгууллагуудад мэдэгдэж, саналыг нь авч хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулах ажлыг 2025 онд багтаан хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Уурхайн үйл ажиллагаа, хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас тоосжилт нэмэгдэх.	Уурхайн дотор талбайн зам арчилгаа усалгааг тогтмол хийх	Ашиглалтын талбай	-	Дотоод зардал		тогтмол	“Агаарын тухай”, “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль	
2	Техникээс үүдэлтэй орчны тоосжилт үүсэх.	Зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулна	Ашиглалтын талбай	-	Дотоод зардал		тогтмол		
5.2. Усны нөөц болон чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
3	Усны зохисгүй хэрэглээ бий болох усны тухай хууль зөрчигдөх	Уурхай, үйлдвэрийн усны хэрэглээнд хяналт тавьж сар бүр тоолуурын заалтыг актаар баталгаажуулан бүртгэх.	Уурхай	сар бүр	-	12	500.0	тогтмол	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль,
	Усны нөөцийн менежментийг сайжруулах	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах	-	-	-	1	650.0	жилд	
		Хаягдал усны зөвшөөрөл авах	-	-	-	1	-	жилд	
5.3. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
7	Хөрсний бүтцэд өөрчлөлт гарах	Шимт хөрсний овоолгыг технологи, стандартын дагуу хадгалах	Ашиглалтын талбай	тогтмол	-	-	дотоод зардал	тогтмол	Газрын тухай хууль MNS 5916:2008 “Газар

9	Хөрс шингэн хатуу, хог хаягдлаар бохирдох	Үйлдвэр уурхайн Ашиглахгүй болсон шороон замыг хаах, нөхөн сэргээх.	Ашиглалтын талбай	тогтмол	-	-	350.0	тогтмол	шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008
5.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
10	Газрыг үр ашиггүй, зохисгүй ашигласнаар газрын шим тэжээл буурах	Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах.	Ашиглалтын талбай	тогтмол	-	-	дотоод зардал	тогтмол	
5.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
11	Амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх , өвс тэжээл байршуулах.	Нөлөөллийн бүс	удаа	-	1	1,000,000	жилд -1 удаа	Амьтны аймгийн тухай" хууль
12		Сум орон нутгийн амьтан хамгаалах үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах	-	удаа			дотоод зардал	тогтмол	
5.6. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах									
13	Уурхай, тээвэрлэлт, шорооны ажлын үед ургамал устгах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөх	Сүхбаатар сумын нутагт Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 1000 ширхэг мод тарина.	Төслийн талбайд	тогтмол	-	-		дотоод зардал	Ургамал хамгааллын тухай” хууль, MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
НИЙТ ЗАРДАЛ							2,500,000		

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Техникийн нөхөн сэргээлт	Баяжуулах үйлдвэрийн орчимд ашиглаж дууссан хүдрийн овоолгын талбайд техникийн сэргээлт хийнэ.	га	0,5	Дотоод төсөв	2,000,000	Тухайн жилдээ	“Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд,
НИЙТ			2,000,000					

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОНБУ-ний тухай хуулийн 3.1.11-д “биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэгийг төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх,хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ” гэж тодорхойлсон. Мөн хуулийн 8.4.6-д“газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлдхаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ” хэрэгжүүлэх гэж, 9.6.-д “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдаххөрөнгө зардлыг тусгасан байна” гэж тус тус заасан.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Улсын тусгай газар хамгаалалттай менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Баянцагаан тал Улсын тусгай хамгаалалттай газар менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	Сүхбаатар сум	1	10,000,000	Тухайн үед техник хэрэгсэл гаргах, дотоод зардал	1 удаа	ЗГ 2013 оны 374-р тогтоол Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
НИЙТ ЗАРДАЛ						10,000,000		

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төлөвлөөгүй	-	-	-	-	-	-	-

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Лицензтэй талбайгаас түүх соёлын дурсгалт олдворуудыг археологийн судалгаагаар илрүүлсэн боловч олборлолтын үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөнө.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төлөвлөөгүй	-	-	-	-	-	-	-

АРАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах.	Төслийн талбайд	1	Үйл ажиллагааны зардалд туссан		тогтмол	Гамшгаас хамгаалах тухай хууль
2		Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг ОБГ-р батлуулж мөрдөх	Төслийн талбайд	1	Үйл ажиллагааны зардалд туссан		тогтмол	
3	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах	Төслийн талбайд	1	Үйл ажиллагааны зардалд туссан		тогтмол	Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
4		Галын зоонуудад үзлэг хийж шаардлагатай бол сайжруулах арга хэмжээ авах	Төслийн талбайд	1	--	тогтмол	тогтмол	

5	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах явцад гэнэтийн осол үүсэж байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй ослын үед ажиллах, төлөвлөгөө боловсруулах заавар боловсруулж, мөрдөж ажиллах	Төслийн талбайд		Үйл ажиллагааны зардалд туссан	тогтмол	Аюултай, хортой химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, тээвэрлэх, ашиглах, үйл ажиллагааг зохицуулах журам 2003 оны 7 –р сарын 1-ний 126/171 Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2009 оны 2-р сарын 3-ны 28/40/29
6		Асгарч гоожсон бодисуудын асгаралт, алдагдлыг зогсоох, зааврын дагуу саармагжуулах, цуглуулах, байгаль орчинд тархахаас сэргийлэх.	Төслийн талбайд		Үйл ажиллагааны зардалд туссан		

АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.

- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, гал тогоо, зэрэг шаардлагатай газруудад байршуулах.	Төслийн талбай	тогтмол	-		1,000,000		Хог хаягдлын тухай хууль, Аюултай хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын тухай журам
2		Хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.	Төслийн талбай	тогтмол	-		-		
3		Баяжуулах үйлдвэрийн орчимд үүссэн төмрийн хаягдлыг төмөр авах цэгт тушаах	Төслийн талбай	тогтмол	-		2,500,000		
4	Аюултай хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан зайлуулах	Төслийн талбай	удаа	-	-	-		
5		Аюултай хог хаягдал хадгалах агуулахтай болох	Төслийн талбай	удаа			Үйл ажиллагаан		

							ы зардал		
	НИЙТ ЗАРДАЛ						3,500,000		

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар							
1	Агаар дахь CO2, NO2, SO2 Тоос нийт (PM10, PM2.5)	Ил уурхай урд-1 цэг Баяжуулах үйлдвэр орчим-1 цэг Хаягдлын овоолоос 100 метр зайд -1 цэг	жилд 1 удаа	1	300,000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2019 Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ	
2	Дуу шуугиан хэмжээний хэмжилт хийх	Уурхайн тээврийн зам-1 цэг Ил уурхайн орчим-1цэг	жилд 1 удаа	1	100,000		
Хөрсний чанар							
3	Хөрсний агрохимийн үзүүлэлт	Төслийн талбайн эрүүл газрын хөрснөөс-1цэг Шимт хөрсний овоолгоос-1 цэг	жилд 1 удаа	1	200,0000		

4	Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)	Баяжуулах үйлдвэр орчим-1 цэг Баяжуулах үйлвэрээс гарч буй хаягдал-1 цэг Хаягдлын далангаас зүүн урд зүгт 100 метр зайд-1 цэг	жилд 1 удаа	1	200,0000	
5	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Хог хаягдлын цэг-1		1	100,0000	
Усны чанар						
6	Физик шинж чанар Химийн найрлага	Гүний худгийн ус-1 цэг Шүүрлийн ус-1 цэг	жилд 1 удаа	1	200,0000	
7	Хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)	Хаягдалын далангийн ойролцоо хяналтийн цэг-1 цэг	жилд 1 удаа	1	200,0000	
НИЙТ ЗАРДАЛ					1,100,000	

АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			сар	сар	сар		
1	Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх	4,000,000	4	5	10	БО-ны мэрэгжилтэн	Үйл ажиллагаа явуулж буй сум орон нутагтай хамтран 1000 ш мод тарих.
2	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж	Дотоод төсөв	тогтмол			БО-ны мэрэгжилтэн	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний

	байх.				тухай хуулийн 14.1.3
	НИЙТ	4,000,000			

**АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ОЛОН НИЙТЭД
ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨ**

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Сум орон нутаг, багийн иргэдэд байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажлын тайлан, хэрэгжилтийг танилцуулах	Илтгэл хэлэлцүүлэг	БО-ны чиглэлээр хийгдэж буй ажлууд, ус ашиглалт болон БО-ны хохирлын төлбөрүүд г.м	Жилд нэг удаа 10 сард	-	БО-ны мэргэжилтэн	Багийн төв
Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд	Хэлэлцүүлэх, хэвэлмэл хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийн талаар - Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах болон бусад мэдээллийг	Жилд нэг удаа	-	БО-ны мэргэжилтэн	Багийн төв
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хэлэлцүүлэх, хэвэлмэл хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүрийн 11 сард	-	БО-ны мэргэжилтэн	Уурхайн бүс

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Зардлын дүн /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,500,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,000,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,500,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,100,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,000,000
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
Нийт зардал /төг/		23,100,000